

MSUCE (NRU) is the construction's intelligence

Үндэсний судалгааны Москвагийн барилгын их сургууль (1993 он хүртэл Москвагийн барилга инженерын институт) – ОХУ-ын барилгын чиглэлээр суралцагчидын сургалтын түвшинд их дээд сургуулиудын толгойн сургууль нь юм. НИУ МГСУ – олон жилийн академийн болон шинжлэх ухааны уламжлагдсан суурь, орчин үеийн судалгаа шинжилгээний төв болон ОХУ-ын мэргэжлийн түвшинд оюуны потенциалыг хөгжүүлэхэд идэвхитэй оролцоход оршино. Тус их сургууль нь орчин үеийн инженер, эрдэмтэд ба мэргэжилтэнгүүдийг бэлтгэхэд шинжлэх ухааны дэвшилтэт шинэ технологи дээр үндэслэн сургалтыг зохион байгуулж боловсон хүчинг бэлтгэн явуулдаг.

НИУ МГСУ нь олон улсын 80 их, дээд сургууль ба 35 орны шинжлэх ухаан сургалтын төвтэй хамтран сургалтын туршилтыг хэрэгжүүлж туршлага солилцохын зэрэгцээ ОХУ болон европын барилгын сургалтын түвшинд идэвхитэй үүргийг гүйцэтгэн нэр хүндийг олон ажиллаж байна. НИУ МГСУ ОХУ-ын их дээд сургуулиудын дунд анхны BREEAM лицензийг авсан.

Тус сургуульд 20 000 оюутан суралцдагаас 74 орны 1000 гаруй гадаадын оюутнууд сурч боловсордог.

Сургалтанд хамрагсадын гэрээг үнэ төлбөргүй ба төлбөр төлөх журмаар өдөр, өдөр-эчнээ, эчнээгээр гэсэн чиглэлээр сургадаг.

Орос хэл сурах болон сургуульд элсэн ороход “Их сургуульд элсэн орж суралцах” хөтөлбөрийн дагуу дараах 6 хичээлүүдээр бэлтгэн сургадаг. Үүнд: орос хэл, математик, физик, мэдээлэл зүй, хими, дүрслэх геометр.

Төлбөртэй гэрээний үндсэн дээр тулгуурласан сурагчдын төлбөр нь 2100-3000 ам. доллар АНУ. Суралцагчдад зориулсан тусгай хамгаалалтай тохилог өрөөнүүдтэй (2 ба 3 хүний) дотуур байр, дотуур байрнаас сургууль хүртэл 10 минут явган явах, улсын зардлаар сурч буй оюутнуудад дотуур байр нь сарын төлбөр 9\$ харин хувийн зардлаар суралцагчдад 18\$ тус тус болно. Суралцагчдад зориулсан шинжлэх ухаан болон техникийн номын сан, спортын ордон, орчин үеийн ая тухтай зоогийн газар, амралтын газар, Олон улсын клуб, сургуулийн соёлын амьдралтай танилцах программ зэрэг сонирхол татах зүйлүүд их бий.



Бакалавараар бэлтгэх чиглэл:

- 01.03.04 Хавсрах математик
- 07.03.01 Архитектур
- 07.03.04 Хот төлөвлөлт
- 08.03.01 Барилга
- 09.03.01 Мэдээлэл зүй ба тооцоолох техник
- 15.03.04 Автомат үйл ажиллагаатай үйлдвэрлэлийн ба технологийн процесс
- 20.03.01 Байгаль орчны аюулгүй байдал
- 27.03.01 Стандар ба метро байгуулалт
- 27.03.04 Техникийн үйл ажиллагааны удирдлага
- 38.03.01 Эдийн засаг

Инженерээр бэлтгэх чиглэл:

- 08.05.01 Өндөр дэвшилтэт барилга ба байгууламж
- 23.05.01 Замын хөдөлгөөний технологи

Магистр бэлтгэх чиглэл:

- 07.04.01 Архитектур
- 07.04.04 Хот төлөвлөлт
- 08.04.01 Барилга
- 15.04.03 Хавсрах механик
- 09.04.01 Мэдээлэл зүй ба тооцоолох техник
- 38.04.01 Эдийн засаг
- 38.04.02 Менежмент